



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2015 оны 09 сарын 22 өдөр

Дугаар А/96

Чингис

Зардал гаргах тухай

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам "Алба хаагчид нэг удаагийн тэтгэмж олгох, хүндэтгэл үзүүлэх" /код 932/ 932.3.1а, 932.6 дэхь заалт, цагдаагийн газрын дотоод журмын 10 дугаар зүйлийн 4 дэхь заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 503 дугаар тушаалаар цэргийн байнгын тэтгэвэрт гарсан цагдаагийн бэлтгэл хурандаа Дэмбэрэлийн Ганхуягийн "Хөдөлмөр алдар"-ыг тэмдэглэх арга хэмжээг байгууллагын хэмжээнд зохион байгуулахыг Батноров сум дахь цагдаагийн хэсгийн дарга, цагдаагийн ахмад Д.Баасандоржид даалгасугай.

2. Цагдаагийн газрын дотоод журмын дагуу бэлтгэл хурандаа Д.Ганхуягт туслах аж ахуйгаас 1 /нэг/ адуу, 4 /дөрөв/ хонь, 3 /гурав/ ямаа, нийт 8 толгой мал олгосугай.

3. Цэргийн байнгын тэтгэвэрт гарч байгаа бэлтгэл хурандаа Д.Ганхуягт өгөх дурсгалын зүйлд 13000 төгрөг /нэг зуун гучин мянган/-ийг цагдаагийн газрын 2015 оны батлагдсан төсвийн тэтгэмж урамшууллын зардлаас санхүүжүүлж зарцуулахыг ахлах нягтлан бодогч, цагдаагийн хошууч Ж.Баатарт зөвшөөрсүгэй.

4. Тушаалыг бүрэлдэхүүнд танилцуулсугай.

ДАРГА ЦАГДААГИЙН
ХУРАНДАА Г.ОРОСТОГОО



005702